



# ДОРНОД АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2014 оны эхний 10 сарын байдлаар)


Чî éáàëñàí õî ò



ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠭᠢᠢᠨ ᠨᠢᠶᠭᠦᠮ ᠡᠳᠢᠶᠢᠨ  
ᠵᠠᠰᠭᠢᠶᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хүн ам

Төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт, 1000 хүнд ногдохоор, жил бүрийн 10 сарын байдлаар




Аймгийн хэмжээнд нийт 1661 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 1662 болж өнгөрсөн оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 17 буюу 1.02%-иар, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 9 буюу 0.5%-иар тус тус өссөн байна.

Хүн амын нас баралт 380 тохиолдол бүртгэгдсэн нь 1000 хүн ам тутамд 5.07 ногдож, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 тохиолдол буюу 5.5%-иар буурсан байна.


Нас баралтын шалтгаанд хорт хавдрын нас баралт 100 тохиолдол бүртгэгдсэн ба нийт нас баралтын 26.3%, осол гэмтлийн нас баралт 75 тохиолдол буюу 19.7 %-ийг тус тус эзэлж байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Эрүүл мэнд


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо  
жил бүрийн 10 сарын байдлаар



Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн 10  
сарын байдлаар



Халдварт өвчнөөр өвчлөгчид, жил бүрийн 10 сарын байдлаар



ᠬᠤᠨ ᠠᠮ, ᠨᠢᠶᠭᠮᠢᠶᠢᠨ ᠤᠵᠦᠭᠦᠯᠡᠯᠲᠤ – ᠡᠷᠦᠭᠦᠯ ᠮᠡᠨᠳᠤ

## ТӨСӨВ САНХҮҮ – Орон нутаг

- **Төсөв, санхүү**: Аймгийн төсвийн нийт орлого 47652.6 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 47515.0 сая төгрөг, үүнээс урсгал орлого 7812.7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 9802.9 сая төгрөгт хүрч 1990.2 сая.төгрөгөөр давж биелэлээ.
- Аймгийн төсвийн нийт зарлага 43994.7 сая төгрөг гарсан бөгөөд гүйцэтгэлийг санхүүжүүлээд байна.
- Сумдын төсвийн зарлага 29107.0 сая төгрөг болсон байна.






- **Гурилын үнэ:** 2014 оны 11 сарын 5-ны байдлаар Дорнод I гурилын 1 кг-ын үнэ 920 төгрөг байна. Энэхүү үнийг 2014 оны 1 дүгээр сарын байдалтай харьцуулбал 43.7 хувиар, 6 сарын үнэтэй харьцуулбал 35.3 хувиар өссөн байна.
- **Махны үнэ:** 2014 оны байдлаар 5 дугаар сард үхэр, хонь, ямааны мах хамгийн өндөр үнэтэй байсан ба оны эхний үнэтэй харьцуулахад 4.0 -7.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
- **Сүү, будаа, элсэн сахар:** Элсэн сахар, цагаан будааны үнэ оны эхнээс 100 төгрөгөөр буюу 5.2 хувиар өссөн. Шингэн сүүний хувьд 2 дугаар сард 1700 төгрөгийн үнэтэй байсан бол улирлаас шалтгаалан зуны улиралд 600 төгрөг хүртлээ буурсан ба 11 сарын 5-ны байдлаар 1200 төгрөгийн үнэтэй байна.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Том малын зүй бус хорогдол




Том малын зүй бус хорогдол 2014 оны 10 сарын байдлаар 7825 толгойд хүрснээс тэмээ 56, адуу 525, үхэр 733, хонь 3738, ямаа 2773 толгойд хүрлээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37498 толгойгоор бага байна. Нийт хорогдлын 27.8 хувийг Баяндун сумын хорогдол эзэлж байна.





# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Хөдөө аж ахуй

Хураан авсан ургац жил бүрийн 10 сарын байдлаар, тн-оор




Энэ онд 8880 мян.га талбайд улаан буудай тариалснаас 14618 тонн улаан буудай, 223.4 га-д төмс тариалснаас 2170.5 тонн, хүнсний ногоо 124.1 га-д тариалснаас 1213.5 тонн төмс хүнсний ногоо тус тус хураан аваад байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад улаан буудай 4715.8 тн буюу 47.6 хувиар их ургац хураан авсан байна.

Малчид 56978.7 тонн хадлан бэлтгэж төлөвлөгөөний биелэлт 106.2 хувьтай байна. Аюулгүйн нөөцөнд 1596 тонн хадлан бэлтгээд байна.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Тээвэр

Тээврийн газраар зорчигчдын  
тоо,  
10-р сарын байдлаар, мян.хүн

Үзүүлэлт	2012	2013	2014
Шуудан үйлчилгээний газар	5	4.6	3.6
Авто тээврийн газар	16.3	20.3	24.4



Тээврийн газрын жил бүрийн 10-р  
сарын байдлаар

	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Шуудан үйлчилгээний газар	0.8	0.9	0.6	2.4	5	4.6	3.6
Авто тээврийн газар	7.5	7.5	3.6	15.5	16.3	20.3	24.4

Шуудан үйлчилгээний газар 3.6 мянган зорчигч тээвэрлэж, 398.1 мянган хүн км-ийн зорчигч эргэлтийн ажил гүйцэтгэн, 15.8 сая.төгрөгийн орлого олсон бол Авто тээврийн газар 24.4 мянган зорчигч тээвэрлэж, 16006.4 мянган хүн км-ийн зорчигч эргэлтийн ажил гүйцэтгэн 52614.3 мян. төгрөгийн орлоготой ажиллажээ.






МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИК АГЫН

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Тээвэр

**Холбооны газрын орлого  
10-р сарын байдлаар, мян.төг**

	2012	2013	2014
Тарифын орлого	312.5	288.8	312.5
Телефон цэг	998	1095	998



**Холбооны орлого жил бүрийн 10-р сарын  
байдлаар**

	2008	2009	2010	2011	2012	2013	2014
Холбооны орлого	473.6	334.8	272.5	288.8	193.7	288.8	312.5

Аймгийн Холбооны газрын нийт орлого 375.2 сая төгрөгт хүрсний 39.4 хувийг хүн амаас орсон орлого эзэлж байна.


# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт,  
2014 оны 10-р сарын байдлаар, сая төг



сая.төг

Үзүүлэлт	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3058.7	8938	39017.7	436.5
Боловсруулах аж үйлдвэр	3542.4	5533.7	6095.7	110.2
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	8984.6	12854.8	15089.2	117.4
Бусад	55.8	43.7	71	162.5



2014 оны 10 сарын байдлаар Дорнод аймгийн аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлт 55337.1 сая төг-өөс 39017.7 сая төг-д хүртэл өсч, 2013 оны 10 сарын байдлаартай харьцуулж 110.2 хувийн өсөлт бүтээжээ.

# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ – Аж үйлдвэр


Аж үйлдвэрийн салбарын нийт борлуулалт,  
2014 оны 10-р сарын байдлаар, сая төг



сая.төг

	2012	2013	2014	$\frac{2014}{2013}$
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	3058.7	8938	39017.7	121.3
Боловсруулах аж үйлдвэр	3237.8	5090.8	6433.4	106.8
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж	7493.3	8362	14533.6	104.7
Бусад	54.5	36.1	71	104.7


**Аж үйлдвэр:** Аж үйлдвэрийн газрууд 60273.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 60055.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлууллаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлдвэрлэлт 120.2% буюу 32903.4 сая төгрөгөөр, борлуулалт 267.8% буюу 37628.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна.




# МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ Нийтийн аж ахуй

## НИЙТИЙН АЖ АХУЙ

Үзүүлэлт	2012	2013	2014
нийт орлого	810.5	807.4	810.5
Үүнээс ус борлуулалт	431.9	421.9	431.9



## Нийтийн аж ахуйн орлого 2008-2014 оны жил бүрийн 10-р сарын байдлаар




Нийтийн аж ахуй ХХК 1476.7 сая төгрөгийн орлоготой ажилласны 38.3 хувь нь хүн амын хэрэгцээнд нийлүүлсэн ус борлуултын орлого эзэлж байна.

# ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ - Хөдөлмөр


Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэд, жил бүрийн 10 сарын байдлаар




Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар



Бүртгэлтэй ажилтгүй иргэд, боловсролын түвшнээр, 2014 оны 10 сарын байдлаар



Шинэ ажлын байранд орсон хүний тоо, насны бүлгээр, 2014 оны 10 дугаар сарын байдлаар



Урьдчилсан гүйцэтгэл





Статистикийн мэдээллийн нэгдсэн сан

**www.1212.mn**



**Статистик мэдээлэл**



**@statistic\_mn**

**Статистик мэдээлэл**

ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠳᠦᠨ  
ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠢᠯᠢ  
ᠨᠡᠭᠦᠳᠦᠰᠢᠨ  
ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢ